



НИЙСЛЭЛИЙН  
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Шинэ коронавирусийн халдвараас  
урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд зарим  
ажилтан, албан хаагчдыг хорогдуулсан  
цагаар ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Засгийн газрын 2020 оны 30, 62, 64 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны "12 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн ажлын цагийг хорогдуулах тухай" А/268 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Томуу, томуу төст өвчний тархалт, шинэ коронавирусийн халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 0-12 хүртэлх насны хүүхэдтэй албан хаагчдын судалгааг гаргаж захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргааны ахлах мэргэжилтэн /Г.Энхтуяа/-д үүрэг болгосугай.

2. Энэхүү зохицуулалтад хамрагдаж байгаа ажилтнуудын ажил үүргийг бүрэн гүйцэтгүүлж, үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохион байгуулан цалин хөлсийг нь ажилласанд тооцож олгохыг хэлтэс, албадын дарга, байр хариуцсан менежерүүдэд тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга /Ч.Шинэчимэг/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х ЭРДЭНЭБИЛЭГ

1150500035